



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот


Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын
хэлтсийн данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл
хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн бууу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бэхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 02 сарын 17-ны өдрийн
А/35 тушаалын хавсралт

СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн , өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Ланд круйзер-80 08-03 УНУ	1994/2014	Суудал ЯПОН Шаргал	HDJ810044683	-	25,000,000	Техникийн комиссын дүгнэлтээр тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн бэлэн байдал алдагдсан, эд ангиудын ашиглалтын хугацаа дууссан, стандартын шаардлага хангахгүй болсон
нийт							25,000,000	